



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 0/440

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 35 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,646,910.38 /гурван сая зургаан зуун дөчин зургаан мянга есөн зуун арван төгрөг гучин найман мөнгө/ бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 35 дугаар цэцэрлэг /Т.Бямбахорол/-д зөвшөөрсүгэй.


2. Хавсралтад дурдсан 5 нэр төрлийн 939,010.38 /есөн зуун гучин есөн мянга арван төгрөг гучин найман мөнгө/ бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 3 нэр төрлийн 2,707,900.0 /хоёр сая долоон зуун долоон мянга есөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 35 дугаар цэцэрлэг /Т.Бямбахорол/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001365

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 11 сарын
25 өдрийн 01470 дүгээр тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 35 дугаар цэцэрлэг

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуул-сан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХК-н шийдвэр
1	Хар сандал	11	ш	5	25,000.00	125,000.00	125,000.00	-	Хөл нь хугарсан элэгдэлд орсон	устгах
3	Ангийн булан	10	ш	1	151,087.68	151,087.68	151,087.68	-	Ашиглах боломжгүй	устгах
Тавилгын дүн						276,087.68	276,087.68	-		
4	Хөлдөөгч 2011	8	ш	1	350,000.00	350,000.00	350,000.00	-	Мотор шатсан сэлбэг байхгүй	устгах
5	Дээжний хөргөгч/мини/	14	ш	1	274,422.70	274,422.70	274,422.70	-	эвдэрсэн	устгах
6	Принтер 3400	6	ш	1	339,900.00	339,900.00	339,900.00	-	Шатсан	татах
7	Ус халуун баригч 2013	6	ш	2	84,000.00	168,000.00	168,000.00	-	эвдэрсэн	татах
8	Свич	7	ш	1	38,500.00	38,500.00	38,500.00	-	Шатсан ажилладаггүй	устгах
9	2-р хоолны тогоо	8	ш	1	2,200,000.00	2,200,000.00	2,200,000.00	-	Тень шатсан Сэлбэг байхгүй	татах
Тоног төх-ийн дүн							3,370,822.70	3,370,822.70	-	
Нийт дүн							3,646,910.38	3,646,910.38	-	
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө									939,010.38	
Татан төвлөрүүлэх хөрөнгө									2,707,900.00	
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/										